

# ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бигэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/03/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Аудитор: Г.Энхдэлгэр Утас: 99002291 Цахим хаяг: <a href="mailto:Enkhdelgerg@audit.gov.mn">Enkhdelgerg@audit.gov.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/ .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/ .....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/ .....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/ ...	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/.....	8
3. Аудитын тайлан.....	8
3.1. Ерөнхий зүйл .....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	10
3.5.1 Орлогын данс .....	11
3.5.2 Зардлын данс .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлсэн сан



БИГЭР СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Д.БАТМӨНХ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 786

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Бигэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бигэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТУВШИНБАЯР

07020507

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	714,548.0	1,069,058.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	284,224.5	417,832.3
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	208,670.3	231,637.2
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	202,419.7	368,055.3
36	НӨӨЦИЙН БАРАА	19,233.6	19,233.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	32,300.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,193,723.6	6,212,786.1
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,193,723.6	6,212,786.1
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	5,072,373.4	6,119,802.3
39300	Биет бус хөрөнгө	121,350.3	92,983.8
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,908,271.7	7,281,844.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	54,407.4	9,503.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	54,407.4	9,503.0
41300	Өглөг	54,407.4	9,503.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,853,864.2	7,272,341.6
51	Засгийн газрын хувь оролцоо	5,853,864.2	7,272,341.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын	1,123,630.3	1,824,262.1
51200	Хуримтлагдсан үр дүн	3,378,423.4	4,281,483.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,351,810.6	1,166,596.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,908,271.7	7,281,844.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,789,300.5	3,656,501.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	92,586.9	81,476.8
110	Орлогын албан татвар	62,320.4	60,502.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	62,320.4	60,502.2
113	Хөрөнгийн албан татвар	2,532.1	2,180.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,734.4	18,794.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,311,089.2	919,402.2
120	Нийтлэг татварын бус орлого	2,311,089.2	919,402.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,385,624.5	2,655,622.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,461,162.1	2,845,914.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,461,162.1	2,845,914.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,761,170.0	2,757,291.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,245,388.7	1,633,320.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,437.6	215,997.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,447.2	83,578.0
2104	Хангамж, бараа материалын зардал	36,068.6	72,041.8
2105	Нормативт зардал	37,919.7	294,392.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	853.4	8,875.7
2107	Томилолт, зочны зардал	3,371.4	6,158.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,149.0	7,338.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	208,534.3	435,589.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	699,992.1	88,622.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,328,138.4	810,586.6
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	63,988.1	290,423.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,264,150.4	520,163.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,610,885.8	2,689,873.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	92,586.9	81,476.8
110	Орлогын албан татвар	62,320.4	60,502.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	62,320.4	60,502.2
113	Хөрөнгийн албан татвар	2,532.1	2,180.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,734.4	18,794.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,091.3	3,866.8
1181	Газрын төлбөр	22,136.1	14,519.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,507.0	408.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	76,475.7	96,680.1
120	Нийтлэг татварын бус орлого	76,475.7	96,680.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,441,823.3	2,511,716.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,340,778.7	2,361,004.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,340,778.7	2,361,004.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,585,269.4	2,270,867.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,246,636.0	1,635,062.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	157,515.0	215,509.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,123.2	86,481.6
2104	Хангамж, бараа материалын зардал	37,290.8	60,423.6
2105	Нормативт зардал	36,803.7	169,741.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	959.4	12,694.3
2107	Томилолт, зочны зардал	3,371.4	6,158.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	5,149.0	19,099.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,420.9	65,696.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	755,509.3	90,136.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	270,107.1	328,869.1
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	47,309.2	195,261.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,309.2	195,261.3
2200	Дотоод эх үүсвэрээр	47,309.2	195,261.3
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(47,309.2)	(195,261.3)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	(68,000.0)	-
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	68,000.0	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	154,797.9	133,607.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	129,426.6	284,224.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	284,224.5	417,832.3

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/**

Кo	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын	Нийт цэвэр
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,589,713.9	3,589,713.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,589,713.9	3,589,713.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-
9	Тайлант үеийн үр дүн	2,264,150.4	2,264,150.4
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,853,864.2	5,853,864.2
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,853,864.2	5,853,864.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,089,728.8	1,089,728.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,943,593.0	6,943,593.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(191,414.5)	(191,414.5)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-
19	Тайлант үеийн үр дүн	520,163.1	520,163.1
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	7,272,341.6	7,272,341.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,580,279.20</b>	<b>2,326,814.66</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,254,925.90</b>	<b>2,163,451.19</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,218,647.90</b>	<b>2,128,232.65</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,654,167.10</b>	<b>1,605,583.55</b>
210101	Үндсэн цалин	1,253,801.20	1,245,708.98
210102	Нэмэгдэл	150,519.40	118,572.76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,500.00	6,146.00
210104	Урамшуулал	101,427.10	100,177.45
210105	Гэрээт ажлын хөлс	140,919.40	134,978.36
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>223,200.10</b>	<b>211,737.98</b>
210201	Тэтгэврийн даатгал	153,850.80	144,805.06
210202	Тэтгэмжийн даатгал	17,336.70	17,066.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,869.80	13,419.50
210204	Ажилгүйдлийн даатгал	3,466.70	3,287.09
210205	Эрүүл мэндийн даатгал	34,676.10	33,159.51
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>91,282.90</b>	<b>86,375.62</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,184.90	9,114.76
210302	Түлш, халаалт	80,600.20	76,813.06
210303	Цэвэр, бохир ус	497.80	447.80
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>61,519.20</b>	<b>57,686.35</b>
210401	Бичиг хэрэг	6,205.50	5,301.28
210402	Тээвэр, шатахуун	33,472.90	32,128.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,786.00	4,669.30
210404	Ном, хэвлэл	950.00	685.52
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,950.00	3,863.10
210406	Бага үнэтэй, турган элэгдэх, ахуйн эд зүйлс	11,154.80	11,038.35
2105	<b>Нормативт зардал</b>	<b>94,079.80</b>	<b>85,180.96</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,981.70	30,850.57
210502	Хоол, хүнс	51,348.10	44,588.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,750.00	9,741.60
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>35,471.30</b>	<b>35,267.22</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,614.10	26,488.60
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	960.00	960.00
210604	Урсгал засвар	7,897.20	7,818.62
2107	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>9,200.00</b>	<b>5,819.00</b>
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	9,200.00	5,819.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.00	0.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	<b>19,624.20</b>	<b>15,943.85</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	13,415.20	12,990.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,428.00	1,034.40
210803	Даатгалын үйлчилгээ	450.00	217.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450.00	235.69
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	337.00	33.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	264.00	0.00
210807	Газрын төлбөр	130.00	88.36
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,000.00	1,344.40
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,103.30</b>	<b>24,638.12</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,834.10	16,372.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,269.20	8,265.30
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,278.00</b>	<b>35,218.54</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>36,278.00</b>	<b>35,218.54</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,888.00	18,013.44
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,390.00	17,205.10
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>218,097.50</b>	<b>163,363.47</b>
223001	Бусад хөрөнгө	218,097.50	163,363.47
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>107,255.80</b>	<b>0.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	107,255.80	0.00
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,580,279.20</b>	<b>2,434,673.05</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,676,335.50</b>	<b>1,660,617.20</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,676,335.50	1,660,617.20
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>696,161.80</b>	<b>677,028.54</b>
320001	Орон нутгийн төсвөөс	553,418.80	534,285.54
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	142,743.00	142,743.00
33	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС</b>	<b>12,206.60</b>	<b>7,804.75</b>
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	12,206.60	7,804.75
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>195,575.30</b>	<b>89,222.56</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,765.70	88,712.78
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	81,896.40	509.78
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	98,913.20	0.00
37	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	97,673.31
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	205,531.69

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	<b>НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>243,886.9</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>243,886.9</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>174,532.4</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>29,478.5</b>
210101	Үндсэн цалин	29,478.5
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>3,771.5</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,771.5
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>106.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	106.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,837.2</b>
210401	Бичиг хэрэг	1,512.2
210402	Тээвэр, шатахуун	880.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-
210404	Ном, хэвлэл	2,345.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100.0
2105	<b>Нормативт зардал</b>	<b>84,560.9</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,956.1
210502	Хоол, хүнс	4,267.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,337.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,975.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,975.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>339.1</b>
210701	Гадаад албан томилолт	-
210702	Дотоод албан томилолт	339.1
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	<b>3,156.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	3,156.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>44,308.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,308.3
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>69,354.4</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>39,200.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,200.0
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>30,154.4</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	30,154.4
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>244,293.5</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>244,293.5</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив,	182.1
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц	25,833.3
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	92,317.3
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	8,301.5
131106	Хаагдсан данс	-
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	117,659.2
III	<b>НИИТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>406.6</b>
9	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	406.6

### 1. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бигэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Бигэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 65 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бигэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн чиг үүргийг хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах ёсны чадавхыг дээшлүүлэх, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх ойрын бодлогыг зөв зохистой тодорхойлох иргэдийн ашгийг хамгаалан, сайн сайхан амьдрах орчин бүрдүүлэх хүний хөгжлийг бүх талаар хангахад оршино” гэсэн эрхэм зорилго тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Бигэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бигэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 1,903.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 38.1 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 3,136.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 62.7 сая төгрөгөөр тооцсон. АДБОУС 2320-н 13-д зааснаар санхүүгийн тайланд анхлан тогтоосноос бага материаллаг байдал зохистой тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Бигэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23 хувиар буюу 1,373.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 284.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 417.8 сая төгрөг болж, 133.6 сая төгрөгөөр өссөн байна. Нийт мөнгөн хөрөнгө нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байгаа бөгөөд үүний 48.0 хувь болох 202.4 сая төгрөг нь сумын ерөнхий орлогын, 2.3 хувь болох 9.5 сая төгрөг нь байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн сангийн, 24.2 хувь болох 101.2 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн, 12.8 хувь болох 53.5 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн, 12.3 хувь болох 51.3 сая төгрөг нь эрүүл мэндийн төвийн дансанд байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 208.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 231.6 сая төгрөг болж, 23.0 сая төгрөгөөр өссөн. Авлагын үлдэгдэлд сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 85.3 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилттэй холбоотой ЭМТ-ийн 143.9 сая төгрөгийн, цалингийн нөхөн олговортой холбоотой Соёлын төвийн 2.4 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Байгууллагаас авах авлага нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн эргэлтийн хөрөнгийн түргэн хөрвөх чадварыг бууруулж цаашид төлөгдөхгүй тохиолдолд үргүй зардал бий болох сөрөг үр дагавартай.

Бараа материалын эхний үлдэгдэл 202.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 368.1 сая төгрөг болж, 165.6 сая төгрөгөөр өссөн, нөөцийн барааны эхний үлдэгдэл 19.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 19.2 сая төгрөг болж өөрчлөлт ороогүй, борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө 32.3 сая төгрөг болж тайлант хугацаанд нэмэгдсэн байна.

Тайлант онд бараа материал 666.3 сая төгрөгөөр нэмэгдсэн ба үүний 52.9 хувь буюу 352.4 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан бэлтгэсэн бол 47.1 хувь буюу 313.9 сая төгрөгийн бараа материалыг хандиваар болон шилжүүлэн авсан бол 500.7 сая төгрөгийн бараа материал хасагдаж оны эцэст 387.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,020.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,600.7 сая төгрөг болж, 1,580.0 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 31.9 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 1,722.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хандиваар, бүтцийн өөрчлөлтөөр, 312.1 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авснаар нийт 2,066.4 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн, 109.9 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 376.5 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн нийт 486.4 сая төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөд 376.8 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан ба шилжүүлсэн болон акталсан хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл болох 229.4 сая төгрөгийг дансны хасалт хэсэгт тайлагнасан байна.

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 54.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9.5 сая төгрөг болж, 44.9 сая төгрөгөөр буурсан байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 9.5 сая төгрөгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн өглөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,853.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 7,272.3 сая төгрөг болж, 1,418.5 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ. Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт 1,089.7 сая төгрөг бүртгэсэн, хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 4,281.5 сая төгрөг болсон байна.

### **3.5.1 Орлогын данс**

Тайлант онд 81.5 сая төгрөгийн татварын орлого, 96.7 сая төгрөгийн татварын бус орлого, 2,511.7 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 2,689.9 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

### **3.5.2 Зардлын данс**

Тайлант онд 2,845.9 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 290.4 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

### **3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт**

Бигэр сумын ИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын “Сумын 2021 оны төсөв нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 18 дугаар тогтоолд зааснаар Бигэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 60.4 сая төгрөгийн татварын, 3.0 сая төгрөгийн татварын бус нийт 63.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 86.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 136 хувиар биелүүлсэн байна.

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн байгууллагуудын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Харин тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын хувьд дээд шатны төсөв захирагчдаа тус тус хүргүүлжээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийг 2,580.3 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 2,580.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,254.9 сая төгрөгийг урсгал зардалд, 218.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлд 107.3 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,676.3 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 553.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 142.7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 12.2 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 98.9 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжих, 96.7 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн авсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,326.8 сая төгрөг буюу 90.2 хувьтай байгаа нь нэгж байгууллагын төсвөөс 34.9 сая төгрөгийн зарцуулаагүй татан төвлөрүүлсэнтэй холбоотой.

Төсвийг бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулаагүй. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 243.9 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 182.1 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 25.8 сая төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 92.3 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 8.3 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 117.7 сая төгрөгийн орлогыг тайлагнан 30.2 сая төгрөгийг оны эцэст татан төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн орлогоос 213.9 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Бигэр сумын ИТХ нь тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн.

Бигэр сумын Соёлын төв нь тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг бүрэн мэдээлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 5.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 15.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангаар өгөгдсөн шийдвэрээс 15.7 сая төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулаагүй байна.

##### Харьяа нэгж байгууллагын тухайд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчдад нэгтгэгдэг нэгж байгууллагуудын шийдвэрийн хэрэгжилтийн талаар аудитын тайланд дэлгэрэнгүй тусгасан болно.

Өмнө онуудад хийгдсэн санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэл, нийцлийн аудитаар өгөгдсөн шийдвэрээс Бигэр сумын ЗДТГ-ын 14.3 сая төгрөгийн төлбөрийн акт, Сум хөгжүүлэх сангийн 2.1 сая төгрөгийн төлбөрийн акт, биелэгдээгүй үлдэгдэлтэй. Хэрэгжээгүй шийдвэрийн тухайд хууль хяналтын байгууллагад шалгагдаж байна.

Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцлох асуудал байхгүй.

### 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллага, 1 санд дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 2 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" 3, "Хязгаарлалттай" 2 дүгнэлт өгсөн байна.

#### **Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад 593.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 260.6 сая төгрөгийн алдааг залруулж, 14.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 318.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Аудитаар өгөгдсөн шийдвэрийг чанартай биелүүлж, нотлох баримтаар дэмжигдсэн хэрэгжилтийг өгөгдсөн хугацаанд ирүүлэхийг анхаарах хэрэгтэй.

#### **Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 3.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэнд 5 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

#### **4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга**

##### **Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийгдсэн залруулга:**

Залруулга хийгдээгүй.

##### **Түүвэрт хамрагдсан байгууллагын тайланд хийгдсэн залруулга:**

Залруулга хийгдээгүй.

#### **4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт**

##### **Түүвэрт хамрагдсан байгууллагын тухайд:**

Төлбөрийн акт тогтоогоогүй.

#### **4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага**

##### **Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд:**

Орон нутгийн хөгжлийн сангийн өөрийн орлогын төлөвлөгөө 0.4 сая төгрөгөөр тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" Бигэр сумын ИТХ-ын 2021 оны 18 дугаар "Сумын 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолтой нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

##### **Түүвэрт хамрагдсан байгууллагын хувьд:**

##### **Бигэр сумын ИТХ**

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

##### **Бигэр сумын Соёлын төв**

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн

хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 0.3 сая төгрөгийн зөрүү тооцоо татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн олговор олгож төсвийг 2.4 сая төгрөгөөр хохироосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ." заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
Төсвийн төвлөрүүлэн захирагч											
Бигэр сумын Төвлөрүүлэн захирагч											
		1	0.4					1	0.4		
Түүвэрт хамрагдсан байгууллага											
Соёлын төв											
		3	2.7					3	2.7		
ИТХ											
		1						1			
<b>Дүн</b>											
		<b>5</b>	<b>3.1</b>					<b>5</b>	<b>3.1</b>		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал										
Төсвийн төвлөрүүлэн захирагч										
Дүн										
Соёлын төв										
ИТХ										
Тахийн талын багийн сургууль										
Дүн										
Нийт дүн	5	3.1					5	3.1		